

ГАЗРЫН ТОСНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ МАТЕРИАЛЫГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХЭД ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ

ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Газрын тосны чиглэлээр хийгдсэн судалгааны материал (геологи, геофизик, өрөмдлөгийн анхдагч материал, тайлан, тэдгээрийн хуулбар, газрын тосны цооногоос авсан чөмөг чулуун ба үйрмэг чулуун дээж, газрын тосны шингэн ба хийн байдалтай дээж, усны дээж, газрын тосны хайгуулын талбайн багц материал, бусад) -ыг боловсруулалт, судалгаа, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгэх зорилгоор Монгол улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолт олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Тодорхойлолт олгох

- 2.1. Газрын тосны газар нь газрын тосны чиглэлээр хийгдсэн хайгуул, судалгааны материал (цаашид судалгааны материал гэх) -ын нэр, төрөл, тоо хэмжээ, тэдгээрийг боловсруулалт, судалгаа, лабораторийн шинжилгээ, туршилтад явуулах үндэслэл бодитой эсэхэд мэргэжлийн зүгээс хяналт тавьж, улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолтыг олгоно.
- 2.2. Судалгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолт авах хүсэлтийг Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Хамтарсан судалгааны гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч, хөрөнгө оруулагч болон газрын тосны хайгуул, судалгааны материалыг сонирхсон хуулийн этгээд, хувь хүн гаргаж болно.
- 2.3. Судалгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолт авахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
 - Судалгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолт хүссэн албан бичиг;
 - Судалгааны материалын боловсруулалт, судалгаа, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгэх талаар ажил гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хуулбар;
 - Энэхүү журмын хавсралт 1-ийн дагуу бүрдүүлсэн улсын хилээр нэвтрүүлэх судалгааны материалын талаархи мэдээлэл;
 - Судалгааны материалыг хилээр биечлэн авч явах тохиолдолд хувь хүний гадаад паспорт, визний хуулбар.
- 2.4. Албан бичгээр гаргасан хүсэлтийг энэхүү журмын 2.3-т заасны дагуу бүрдүүлсэн материалын хамт хүлээн авснаас хойш хэрэв нэмэлт тодруулга, хяналт шаардлагагүй бол улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолтыг олгох эсэхийг ажлын тав (5) хоногт багтааж шийдвэрлэнэ.

- 2.5. **Энэхүү журмын 2.3-т заасны дагуу бүрдүүлж ирүүлсэн материалыг хянаж, шаардлага хангасан бол тухайн асуудал хариуцсан хэлтсийн дарга нар тодорхойлолтыг олгоно.**
- 2.6. Улсын хилээр нэвтрүүлэх тодорхойлолт авсан судалгааны материалыг газрын тосны газрын төлөөлөгч болон мэргэжилтнээр газар дээр нь заавал шалгуулж, баталгаажуулсны дараа хилээр нэвтрүүлнэ.
- 2.7. Газрын тосны битүүмжилсэн зарим дээж болон чөмөг чулуун ба үйрмэг чулуун дээжийг шаардлагатай гэж үзвэл хилээр нэвтрүүлэхэд Газрын тосны газраас газар дээр очиж нягтлан шалгаж болно.
- 2.8. Чөмөг чулуун ба үйрмэг чулуун дээж, газрын тосны шингэн, хийн байдалтай дээж, усны дээжийг хилээр нэвтрүүлэх тодорхойлолт авахад энэхүү журмын Хавсралт 1; геологи, геофизик, өрөмдлөгийн анхдагч материал, тайлан, тэдгээрийн хуулбар, газрын тосны хайгуулын талбайн багц материал зэрэг судалгааны бусад материалыг Хавсралт 2-ын дагуу тус тус мэдүүлнэ.
- 2.9. Газрын тосны шингэн, хийн байдалтай дээж, усны дээжний лабораторийн шинжилгээ, туршилтын үр дүнг тэдгээрийг хилээр гаргаснаас хойш 1 сарын дараа, чөмөг чулуун ба үйрмэг чулуун дээж болон бусад судалгааны материалын лабораторийн шинжилгээ, туршилт, боловсруулалтын үр дүнг 1 жилийн дотор Газрын тосны газарт ирүүлнэ.
- 2.10. Бүтнээр гаргасан чөмөг чулуун дээжний дубликатыг тухай дээж хилээр гарсан өдрөөс хойш 1 жилийн дотор буцаан ирүүлж, Газрын тосны газарт хүлээлгэн өгнө.
- 2.11. Улсын хилээр гаргасан судалгааны материалын лабораторийн шинжилгээ, туршилт, боловсруулалтын үр дүн болон бүтнээр гаргасан чөмөг чулуун дээжний дубликатыг журамд заасан хугацаанд Газрын тосны газарт ирүүлээгүй бол цаашид судалгааны материалыг хилээр гаргах зөвшөөрөл олгогдохгүй болно.

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ
СУДАЛГААНЫ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

д/д	Дээж авсан цооног/ дээжний дугаар	Дээжний бодит урт, м	Дээжний жин /кг, л/	Хилээр нэвтрүүлж буй зорилго, хугацаа	Тэмдэглэл
1					
2					
	Нийт дүн				

Жич: Тэмдэглэлийн хэсгийг хяналт хийсэн Газрын тосны газрын мэргэжилтэн /
төлөөлөгч бөглөнө.

Дээжийг хилээр нэвтрүүлэх тодорхойлолтын дагуу газар дээр нь хянасан:

Газрын /...../ тосны газрын /...../
(албан тушаал) (гарын үсэг)
(нэр)

Төлөөлөгчийн /...../ албаны дарга
(гарын үсэг) (нэр)

Огноо:

УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ СУДАЛГААНЫ
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

д/д	Судалгааны материалын нэр	Судалгааны материалын тоо, хэмжээ	Хилээр нэвтрүүлж буй зорилго, хугацаа	Тэмдэглэл
1	3490E маркийн картридж	23 ширхэг	Чичирхийллийн судалгааны анхдагч материалыг	Хувийг ГТГ –т өгсөн
2	Мини CD	5 ширхэг	боловсруулж, тайлал хийх,	-
3	CD	1 ширхэг	1 жилийн хугацаанд хариуг буцаан ирүүлэх	-
4	Зүсэлтийн зураг	10 ширхэг		-
5	Хэвлэмэл материал	764 хуудас		-

*Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 362 дугаар
тушаалаар батлагдсан журмын хавсралт*

Гаалийн ерөнхий газрын харъяа
..... гаалийн хороо /газарт/

**ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ОНЦЛОГ
БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

1	Тодорхойлолт авч буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний овог, нэр, хаяг, регистр, утас, факсын дугаар	
2	Гаалийн хилээр нэвтрүүлэх үндэслэл болох баримт, түүний дугаар (гэрээ, протокол г.м)	
3	Барааны нэр, тоо хэмжээ (хэвлэмэл материалын хуудасны тоо хэмжээ г.м), үнэ	
4	Барааны код	
5	Хилээр нэвтрүүлж буй зорилго, хугацаа	
6	Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн төрөл, боомтын нэр	
7	Хилээр нэвтрүүлэх он, сар, өдөр	
8	Хүлээн авагчийн хаяг	

Жич: Энэхүү тодорхойлолт нь Газрын тосны газрын даргын 2009 оны 115 дугаар тушаалаар батлагдсан журмын хавсралтгүй бол хүчингүй.

Зөвшөөрөл олгосон:

Газрын тосны газар
/ГХСХ/ -н (доогуур зурах) дарга

/..... /

(гарын үсэг)

(нэр)

Тэмдэг

Гаалийн мэдүүлгийн дугаар
